

БАГА, ЖИЖИГ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ДИПЛОМАТ АЖИЛЛАГААНЫ ҮҮРЭГ

Г. Төмөрчулуун*

Та бүхний энэ өглөөний амар амгаланг айлтгая.

Э

нэ сэдвийн хүрээнд би дараах 5 асуудлыг хөндөхийг хүсч байна. Тухайлбал,

- Бага, жижиг улсын гадаад бодлого ба дипломат ажиллагаа
- Дипломат төлөөлөл
- Дипломат сургалт
- Дипломат хэрэгсэл ба үйлчилгээ
- Бага улсын дипломат ажиллагаа ба бүс нутгийн асуудлууд

Оршил

Бага улсууд бол олон улсын хамтын нийгэмлэгийн идэвхтэй гишүүд мөн. Олон улсын харилцаан дахь бага улсуудын нийтлэг шинж бол үгээр итгүүлэх, зөвшилцөлд хүрэх явдал байдаг. Чингэхдээ бага улсууд олон улсын эрх зүйд, олон улсын байгууллагуудад тулгуурлаж үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд олон улсын эрх зүй, олон улсын байгууллагууд энэ утгаараа бага улсуудын заяаны хань болдог юм.

Бага улсуудын хувь заяа тэдгээрийн хил хязгаараас гаднах үйл явдлаас ихээхэн шалтгаалдаг. Жишээ нь бага улсууд нь дэлхийн цаг агаарын өөрчлөлт, байгалийн гамшгаас ихээхэн хамааралтай. Олонх бага улсууд дэлхийн эдийн засгийн хямралд өртөхдөө хялбар, худалдааны элдэв гэрээ хэлэлцээр, хөрөнгө оруулалт, мөнгө санхүүгийн элдэв үзэгдэлд эмзэг байдаг. Аюулгүй байдлын талаасаа гэвэл бага улсууд бүс нутгийн болон дэлхий дахины шинжтэй хямрал мөргөлдөөнд илүү өртөмтгий байдаг.

* ГХЯ-ны Бодлого төлөвлөлт, мэдээлэл, үнэлгээний газрын дэд захирал, доктор (Sc.D), МУИС-ийн хүндэт доктор

Эдгээр хүчин зүйлүүд нь бага улсуудыг олон улсын хамтын ажиллагааг аяндаа дэмжигчид болгодог бөгөөд дипломат ажиллагаа нь олон улсын тавцанд тэдгээрээс дуу хоолойгоо сонсгох гол арга болдог.

1. Гадаад бодлого ба дипломат ажиллагаа

Гадаад бодлого гэдэг бол бодит хүчин зүйлүүдийн үр дүн байдаг бөгөөд эдгээр хүчин зүйлүүд нь гадаад бодлогын шийдвэрийн үндэс суурь болж өгдөг. Жишээ нь арлын жижиг улсууд дэлхийн цаг уурын өөрчлөлтийг бусад улсуудаас түрүүлж мэдэрсэн байдаг. Иймд дэлхийн цаг уурын өөрчлөлттэй холбоотой асуудал нь энэ бүлэг улсуудын хувьд гадаад бодлогын амин чухал чиглэл болдог. Дэлхийн цаг агаарын өөрчлөлттэй дотоод бодлогоор тэмцэх аргагүй тул дипломат ажиллагаа түүнтэй тэмцэх гол арга зам болдог байна. Иймд дипломат ажиллагаа бол бага улсуудын эцсийн хорогдох байр, тэдгээрийн оршин тогтнох үндэс болж байдаг.

Гадаад бодлого өөртөө тохирсон дипломат ажиллагааг эс сонговол утгаа алдана. Хоёр төрлийн дипломат ажиллагаа байдаг, эдгээрийн нэг нь хүч- Realpolitik-т нөгөө нь хэлэлцээнд тулгуурладаг. Николо Макиавели өөрийн хунтайжид зөвлөхдөө “Хууль, хүч гэсэн тэмцлийн хоёр хэлбэр байдаг. Эхний аргыг хүмүүс, хоёр дахийг нь адгуус хэрэглэдэг юм” гэсэн байдаг.

Тууштай гадаад бодлоготой байх нь чухал авч тууштай дипломат ажиллагаатай байх нь түүнээс ч чухал юм. Энэхүү дипломат ажиллагаа нэгдмэл нэг зорилгод хүрэхэд чиглэж, тэр зорилгодоо хүрэхийн тулд төрийн болон төрийн бус бүх байгууллагууд хүч хавсран нэгдмэл байдлаар ажиллах ёстой юм.

Хэрэв чингэж чадвал бага улс хэм хэмжээ тогтоогч, дэлхийн ухамсрыг бий болгогч болж чадах юм.

Бага, жижиг улсын тухай тодорхойлолт. 1985 онд Их Британийн хамтын нийгэмлэгээс гаргасан илтгэлд бага улс гэж нэг сая буюу түүнээс бага хүн амтай улсыг хэлнэ гэжээ. Дэлхийн Банкнаас гаргасан илтгэлд 1.5 сая хүнтэй улсыг бага улс гэж үзсэн байна. Энэ категорит 45 улс багтаж байна. Нөгөө талаас Сингапурын санаачилгаар НҮБ-ын дэргэд байгуулагдсан Жижиг улсуудын Чуулганаас 10 саяас доош хүнтэй улсыг бага улс гэж тодорхойлжээ. Энэ нөхцөлд 93 улс бага улсын тоонд орох аж. Үүний зэрэгцээ

микро улс гэсэн тодорхойлолт мөн гарсан бөгөөд үүнд хагас саяас бага хүн амтай улсуудыг оруулж байна. Хэд хэдэн шалгуурыг авч үзэх хэрэгтэй болно. Үүнд:

- Хүн ам /1.5-5 сая/
- Газар нутгийн хэмжээ /арлын улсуудын хувьд илүү тохиромжтой/.
- Баялаг /бага газар нутагтай боловч орлого өндөртэй улс байдаг. Нефтээр баян Оман, Катарыг Ботсвана, Намибтай харьцуулахад хэцүү/.
- Эмзэг байдал: ядуурал, эдийн засгийн сул дорой байдал гм.

2. Дипломат төлөөлөл

Бага улсын дипломат төлөөл ямар байх ёстой вэ? Тэдгээр нь ямар онцлогтой вэ? гэдэг талаар бага улсуудын гадаад бодлогыг судалдаг эрдэмтэд, судлаачид нэн ялангуяа сүүлийн хориод жил ихээхэн хүч чармайлт тавьдаг болжээ.

Өнөөдрийн бага улсын дипломатууд олон ажлыг зэрэг хариуцан ажиллах болж байна. Тэд зөвхөн хоёр талын ажиллагааны зэрэгцээ олон талт үйл ажиллагаанд оролцох зайлшгүй шаардлагатай тулгарч байна. Тэд улс төрийн асуудлын зэрэгцээ, худалдаа эдийн засгийн асуудал, олон талт дипломат үйл ажиллагаанд оролцох, иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах зэрэг консулын ажлыг ч хийх хэрэгтэй болж байна. Гэтэл энэ бүхнийг амжуулах нөөц бололцоо нь хязгаарлагдмал байна.

НҮБ-ын системийн байгууллагуудыг аваад үзье. Энэ оны НҮБ-ын ЕА-н хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд 154 асуудал тусгагджээ. Энэ оны 1 дүгээр сарын байдлаар ЕА-гаар хэлэлцүүлэхээр 255 тогтоолын төслийг санал болгосон байна. НҮБ-ын 38 салбар дэлхийн 17 улсын 19 хотод тарж байрлажээ. 2700 орчим ТББ ЭКОСОС-ын дэргэд бүртгэлтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Үүний зэрэгцээ бүс нутгийн олон талт хамтын ажиллагаа байна. Жишээ нь АСЕАН-ы Бүсийн Чуулга, АСЕМ-ийн хурал зөвлөлгөөн гэх мэт. Үүн дээр хоёр талын айлчлал, арга хэмжээг нэмбэл бага жижиг улсад дааж давшгүй даваа болох нь харагдана.

Бага жижиг улсуудын хувьд энэ бүхэнд оролцоно гэдэг бараг бүтэшгүй зүйл юм.

Дипломат төлөөллийн уламжлалт хэлбэрүүд өдгөө олон шинэлэг санаануудаар баяжиж байгааг хэлэх хэрэгтэй.

Бага улсууд дэлхийн бүх улсад ДТГ-тай байна гэдэг нь мэдээж бүтэшгүй зүйл. Бага улсуудын практикаас харахад янз янзын л дүр зураг харагдаж байдаг. Жишээ нь

700.000 хүн амтай Бутан улс Энэтхэг, Бангладеш, Балба, Тайланд улсад ЭСЯ-тай, НҮБ-д БТГ-тай, нийт дөрвөн ЭСЯ, нэг БТГ-тай байна¹. Гэтэл Куба улс 133 (үүнээс 104 нь ЭСЯ), ДКТГ-тай байх жишээтэй². Монгол улс 26 ДТГ, 8 КТГ-тай байна³.

Монгол улсын төлөөллийг авч үзвэл Европ тал нь дийлсэн, урьдын практик хэвээр явж ирсэн байдалтай. Болгар, Польш, Унгар, Чех зэрэг улс Европын Холбоонд аль хэдийн нэгдсэн боловч бид эдгээр улсад ЭСЯ-аа байлгасаар байгаа. Гэтэл Ази, Номхон далайн Австрали, АСЕАН-ы орнууд зэрэг манай төлөөлөл байх ёстой газруудад төлөөлөл байхгүй байгаа.

Бага, жижиг улсууд олон улсын харилцаанд төлөөлөлтэй байхын тулд эрэл хайгуул хийсээр иржээ.

Өргөмжит консулын институт. Энэ хэлбэр бол бага улсуудын хувьд, зардал багатай, үр өгөөж сайтай хэлбэр юм. Өдгөө Монгол улсын 53 өргөмжит консул дэлхийн олон оронд ажиллаж байна. Ялангуяа Монгол улсын ЭСЯ байдаггүй газарт эдгээр өргөмжит консулууд чухал үүрэг гүйцэтгэж байна. Энэ бол 90-ээд онд манай дипломат албанд гарсан нэг чухал өөрчлөлт юм.

Байнгын бус Элчин сайд. Өргөмжит консулуудын зэрэгцээ байнгын бус элчин сайдын институт мөн чухал үүрэгтэй гэдэг нь бага, жижиг улсуудын практикаас харагддаг. Скандинавын орнууд, Сингапур⁴ энэ тал дээр ихээхэн туршлага хуримтлуулжээ. Хувийн болон төрийн түншлэлийг хослуулдгаараа онцлогтой байна. Хорват, Финлянд зэрэг улсууд мөн ийм парктикийг өргөн хэрэглэж байна.

Дипломат төлөөллийн дараагийн нэг шинэ хэлбэрийг **цахим төлөөлөл** гэж нэрлэж болохоор. Орон хариуцсан юмуу олон улсын байгууллагаа хариуцсан дипломат ажилтан интернетээр дамжуулан тухайн улс олон улсын байгууллагатай шууд харилцааг практикийг хэлдэг байна. Ийм хэлбэр мөн л зардал өртөг багатай, асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэх нэг арга юм. Куук арал, Сейшелийн арал хоёр тун сайн вэб хуудастай байдаг гэж Австрийн эрдэмтэн Дитрих Капплер “Дипломатын шинэ хэрэгсэл ба хөгжиж байгаа орнууд” номондоо бичсэн байх юм. Гэвч энэ ажиллагаанд мэдээллийн технологийн өндөр түвшинд хүрсэн байх шаардлагатай.

¹ *Ali Nassar Mohamed, The Diplomacy of Micro-states/Studies in Diplomacy No. 72, Clingendael Institute, The Hague, January 2002/*

² www.europanubaminrex

³ Монгол Улсын Гадаад бодлогын Хөх ном, 2006 онв 138 х.

⁴ Жишээ нь Сингапур улс 25 ийм байнгын бус элчин сайдтай байдаг аж. Тэд жилд 3-аас доошгүй удаа хариуцсан улсаа очиж ажилладаг байна. Тэдгээр элчин сайд нар нь бизнесийн болон эрдэм шинжилгээний төлөөлөгчид байх бөгөөд суугаа орондоо очихдоо ГХЯ-ны ажилтныг дагуулж явдаг байна.

Бага улсын дипломат ажиллагааны онцлогууд ба төрлүүд.

Онцлогууд:

- ❖ Бага жижиг улсууд олон улсын эрх зүйг дээдлэн шүтэж, НҮБ, түүний системийн байгууллагууд, олон талт хамтын ажиллагааг илүү эрхэмлэдэг (Сингапур, Мальта хоёр жишээ нь далайн эрх зүй, Тринидадг ба Тобаго, ОУЭШ-ийг бий болгоход ихээхэн үүрэг гүйцэтгэсэн байдаг). Бага улс хуульд, их гүрэн хүчинд дулдуйддаг. Иймд олон улсын эрх зүй, олон улсын байгууллагууд нь бага улсуудын заяаны хань байдаг.
- ❖ Эдгээр улсууд бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх бодит сонирхолтой байдаг (КАРИКОМ-ын 16 улс, Номхон далайн арлуудын чуулга).
- ❖ Чингэхдээ бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааг тэргүүн зэрэгт тавьдаг (татвараас чөлөөлөх, нэгдмэл зах зээлтэй болох, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах, харилцаа холбоо, зам тээвэр зэрэг нийтлэг дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг нийтлэг зорилгын үүднээс).
- ❖ Бага, жижиг улсууд олон талт хамтын ажиллагаанд илүү ач холбогдол өгдөг. Учир нь ингэж ажилласнаар олон талт үйл ажиллагаанд оролцоод зогсохгүй мөн хоёр талын асуудлыг шийдвэрлэхэд дөхөмтэй байдаг.
- ❖ Бага жижиг улсуудын эдийн засгийн дипломат ажиллагаа ерөнхийдээ сул байдаг. Энэ нь эдгээр улсын чадавхитай холбоотой өөрөөр хэлбэл хүний нөөц, зохион байгуулах чадавхи султай холбоотой байдаг байна.

Бага, жижиг улсын дипломат ажиллагааны төрлүүд. Зургаан төрөл байдаг гэж Америкийн эрдэмтэн Алан Хэнриксэн бичсэн байдаг. Үүнийг нийлүүлээд нэгтгэж үзвэл гурван хос дипломатын төрөл байдаг байна. Үүнд:

- ***“Тайван” дипломат ажиллагаа.*** Ийм ажиллагаа гол төлөв хуучин эзэнт гүрэн, шинээр тусгаар тогтносон жижиг улсуудын хооронд явагддаг. Үүний тодорхой жишээ бол Их Британийн хамтын нийгэмлэгт ордог, хуучин Английн колони байсан улсууд юм. Бүр тодорхой яривал КАРИКОМ-ын жижиг улсууд, Английн хоорондын харилцааг иш татаж болох юм. Ийм харилцаа нь түүх, соёл, хэлэнд тулгуурласан тусгай харилцаа байдаг байна. Дипломат ажиллагаа ерөнхийдээ тайван байдалд явагддаг. Тайван дипломат ажиллагааны эсрэг тал ***эсэргүүцлийн дипломат ажиллагаа*** байдаг. Хойд

Солонгос, Зимбабве, Куба, бүр сүүлийн үед Гүржийн дипломат ажиллааг энэ төрөлд хамруулж болно.

- **Хамтын дипломат ажиллагаа.** Энэ ажиллагааны үед хэсэг бүлэг орнууд элдэв үндэслэлээр нэгдэж нэгдмэл үйл ажиллагаа явуулдаг. Жишээ нь 77-гийн бүлэг, далайд гарцгүй орнуудын бүлэг, арлын жижиг улсуудын бүлэг гэх мэт. Хамтын дипломат ажиллагааны эсрэг тал нь **ганцаарчилсан дипломат ажиллагаа** байдаг. Үүний жишээ олон улсын хямралыг зохицуулахын төлөө Норвегийн үйл ажиллагаа, газрын минийг хориглоход чиглэсэн Канадын дипломат ажиллагаа, их далайн ёроолыг хүн төрөлхтний өмчөөр тунхаглах тухай Мальтын санаачилга гм.
- Бага жижиг улсуудын гуравдахь хос нь **популист буюу нэр хүндийн төлөө дипломат ажиллагаа** юм. Энэ ангилалд Венесуэлийн ерөнхийлөгч Уго Чавесын Латин Америкийг АНУ-ын эсрэг чиглүүлэх гэсэн үйл ажиллагаа юмуу Африкийн нэгдлийн төлөө Кадаффийн бодлогыг оруулж нэрлэж болох юм. Мөн Колумб дахь хар тамхины наймаатай холбогдсон үйл ажиллагаа эсвэл Панамын сувагтай холбоотой Панамын засгийн газрын үйл ажиллагааг оруулж болох юм. Энэ бодлогын эсрэг тал нь **зохицуулах дипломат ажиллагаа** юм. Үүнд хар тамхины хууль бус наймаа, мөнгө угаах гэх мэт олон улсын эрх зүйг зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой үйл ажиллагаа орж байна.

3. Дипломат сургалт

Хамгийн авьяаслаг мэрэгжлийн дипломатуудын нэг хэмээгддэг мисье Жюль Гамбон хэлэхдээ засгийн газрын мэдэлд байдаг хамгийн хүчтэй зэвсэг бол шударга хүний үг мөн гэжээ. Сэр Эрнст Сатоугийн бодлоор бол дипломат ажиллагаа гэдэг нь тусгаар улсуудын засгийн газруудын хооронд албан ёсны харилцаа барихад ухаан зарж, авьяасаа нээн харуулахыг хэлнэ” гэжээ. Эдгээр хүмүүсийн хэлсэн дээрх үг дипломат ажиллагааны мөн чанарыг өдгөөг хүртэл харуулж иржээ. Бага улсын хүчтэй дипломат ажиллагаа дараах хоёр зүйл ур чадварт тулгуурлах ёстой гэдэг нь энэ сэдвээр бичдэг эрдэмтэн мэргэдийн айлтгалаас ойлгогдож байна. Үүнд:

❖ **Ерөнхий ур чадвар**

- Холбоотон олох, дайснаа итгүүлж үнэмшүүлэх, суртал ухуулгаар дамжуулан өөрийн тухай төсөөллийг саармагжуулж чадах чадвар бол аугаа их цэргийн хүч, армитай байхаас илүү чадвар гэдгийг үргэлж санаж явах;
 - Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх, шинийг сэдэх, шинийг бүтээх нь дайны стратеги, тактикийг төлөвлөж боловсруулахаас илүү хэрэгтэй зүйл гэдгийг үргэлж бодож санах;
 - Гадаад бодлогын эрхлэн явуулах хамгийн гол нөхцөл бол сөргөлдөөнийг задлан шинжилж, хэрэгтэйг нь хэрэггүйгээс ялгаж салгах, хорвоо дэлхийг нэгдмэл нэг цогцос гэж үзэх, цаг хугацаа, орон зайны хүчин зүйлийг тооцох, үүнд үндэслэсэн мэдлэг оюунаа өөрийн улсын үндэсний эрх ашгийг урагшлуулах зорилгод ашиглахдаа юмыг сүйтгэхээс бус, бий болгодоггүй хүчирхийллийн арга барилаас сэрэмжилж сурах;
 - Үндэстэн улсууд өөр хоорондоо эд баялаг, нөөцийн төлөө, худалдааны зах зээлийн төлөө, нарийн мэргэжлийн оюуны ололтын төлөө, амьдралын эрхэм дээд сайхан нөхцлийн төлөө өрсөлддөг. Энэ зорилгодоо хүрсэн нэг нь өсөж өндийж, хөгжин цэцэглэх бөгөөд хүрээгүй нэг нь унаж, уруудан, сөнөж сүүрдэг жамтайг үргэлж бодох.
- ❖ *Дипломат ажиллагаанд дараах чадвар эн тэргүүнд шаардагддаг:*
- үргэлж нөөц хувилбартай байх,
 - нөөц хувилбараас гарах ашиг хонжоо, гарз хохирлыг нарийн тооцох,
 - бодитой юмыг магадгүй юмнаас ялгаж, салгаж сурах
 - юмыг нөгөө талын нүдээр харж сурах
 - хэрэгтэй мэдээллийг хэрэггүй, завсрын мэдээллээс ялгаж салгаж сурах,
 - яаруу давчуу шийдвэр гаргахаас үргэлж сэрэмжлэх
 - өөрийгөө бусдын оронд тавьж сурах, бодитой юмыг хүссэн юмнаас салгаж сурах.

4. Дипломатын хэрэгсэл

- *Хэлэлцээ.* Хоёр талын болон олон талын хэлэлцээ хийх ур чадварыг төгс эзэмших. Тэгэхдээ том гүрнүүдийн дипломатчдаас илүү энэ урлагийг эзэмшсэн байх;

- **Олон нийтийн дипломат ажиллагаа.** Өөрийн орны имижийг бүрдүүлэх, улс орноо таниулах, сурталчлах;
- **Хямралын менежмент.** Аливаа хямрал гарахад бэлтгэлтэй байх. Асуудлыг түргэн шуурхай, өөртөө ашигтайгаар шийдвэрлэхыг зорих.

5. Бага жижиг улсын бүс нутгийн дипломат ажиллагаа

Бага улсууд газар зүйн байрлалын онцлогт тулгарсан улс төр, эдийн засгийн зорилтуудаа шийдвэрлэхийн тулд тодорхой бүлэглэлүүдэд нэгдэж хамтын дипломат үйл ажиллагаа явуулдгийг би дээр хэлсэн.

Монгол улс ЗХА-д харьяалагддаг. Төв Азид гэж ярьж бичих нь бас бий. Гэтэл хамтын дипломат ажиллагаа явуулж байгаа жишээ бол алга байна. ЗХА-ийн тухайд Хятад, Япон, Солонгосыг юуны өмнө авч үздэг. Төв Ази гэхлээр лалын шашинтай хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан улсуудыг нэрэлдэг. 800 жилийн өмнө Их Монгол улсын бүрэлдэхүүнд багтаж байсныг эс тооцвол нийтлэг зүйл төдийлэн үгүй.

Монголын гадаад бодлогын үндсэн чиглэл нь газар зүйн талаасаа Зүүн Ази болж таарч байна. Зүүн Ази гэдэгт ЗХА, ЗӨА, ӨА, Номхон далай гэсэн үндсэндээ дөрвөн салбар бүс нутаг багтаж байна. Энд интеграцийн үйл явц Зүүн Азийн хамтын нийгэмлэг хэлбэрээр нэгэнт эхэлчихээд байгаа. Гэвч Зүүн Азийн хамтын нийгэмлэгт орохын тулд АСЕАН-тай сайтар ажиллах хэрэгтэй болж байна. Иймд Монголын дипломат ажиллагааны нэг томоохон зорилт АСЕАН-тай ойртох, улмаар АСЕАН-ы хамтын ажиллагааны түнш болоход чиглэх хэрэгтэй байна.

Энэ зорилтыг хэрэгжүүлж чадвал Монголын хөгжил дэвшил, түүний гадаад аюулгүй байдлын нэгээхэн том асуудал шийдвэрлэгдэх юм.